



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НАЛАЙХ ДҮҮРЭГ ДЭХ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/242/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261628 Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК
Захирал: Х.Ариунзул
Утас: 11-450410 Цахим хаяг: ikhnyadaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын санал, дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Албан шаардлага	19
4.3 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандарт

ХХОАТ Хувь Хүний Орлогын Албан Татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НАЛАЙХ ДҮҮРЭГ ДЭХ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ДАРГА С.МӨНХБАТ
ТАНАА

2022.02.24 № 07/321
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	393,920,902.61	394,075,265.10
33	АВЛАГА		408,475.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага		408,475.00
35	БАРАА МАТЕРИАЛ	393,920,902.61	393,666,790.10
35400	Хангамжийн материал	393,920,902.61	393,666,790.10
35410	Бичиг хэргийн материал	6,613,980.00	4,977,130.00
35420	Аж ахуйн материал	43,638,805.60	28,299,775.60
35440	Түлш, шатах тослох материал	1,820,000.00	236,000.00
35460	Хүнсний материал	5,605,419.60	15,069,169.30
35470	Бусад хангамжийн материал	336,242,697.41	345,084,715.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	8,760,576,079.91	12,190,830,049.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,760,576,079.91	12,190,830,049.79
39200	Биет хөрөнгө	8,068,921,768.87	11,500,054,599.67
39201	Барилга, байгууламж	7,689,952,576.59	10,126,885,962.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(513,366,357.36)	(792,813,976.11)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	166,750,000.00	1,461,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл-Тээврийн хэрэгсэл	(94,820,312.50)	(269,247,530.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,238,325,832.76	2,547,345,872.30
39206	Хуримтлагдсан элэгдэл- Тоног төхөөрөмж	(1,530,282,671.76)	(1,635,548,218.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	398,507,490.02	386,821,665.18
39208	Хуримтлагдсан элэгдэл- Тавилга	(311,020,582.88)	(359,584,247.70)
39217	Номын фонд	24,875,794.00	34,495,072.00
393	Биет бус хөрөнгө	691,654,311.04	690,775,450.12
39303	Бусад биет бус хөрөнгө	713,033,758.00	713,677,258.00
39304	Хасагдуулга	(21,379,446.96)	(22,901,807.88)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	9,154,496,982.52	12,584,905,314.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	160,878.18	5,502,624.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	160,878.18	5,502,624.80
413	Өглөг	160,878.18	5,502,624.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,999.18	5,456,424.80
4136	Бусад өглөг	153,879.00	46,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	153,879.00	46,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	9,154,336,104.34	12,579,402,690.09
51	Засгийн газрын хувь оролцоо	9,154,336,104.34	12,579,402,690.09
51100	ЗГ-ын оруулсан капитал /ЗГ-ын сан/ орон нутгийн сан	2,346,405,152.09	2,346,405,152.09
51101	Өмч: төрийн өмч	2,346,405,152.09	2,346,405,152.09
	Хуримтлагдсан үр дүн	(1,053,063,121.46)	2,372,464,361.65
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,636,244,315.56)	(1,052,602,224.10)
51220	Тайлант үеийн үр дүн	583,181,194.10	3,425,066,585.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,860,994,073.71	7,860,533,176.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	9,154,496,982.52	12,584,905,314.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,101,464,410.00	6,179,548,503.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	986,447,910.00	4,094,174,203.09
120	Нийтлэг татварын бус орлого	986,447,910.00	4,094,174,203.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	986,447,910.00	4,094,174,203.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,712,260.00	10,009,693.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	980,735,650.00	4,084,164,510.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,115,016,500.00	2,085,374,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,112,616,500.00	2,061,474,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,112,616,500.00	2,061,474,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,400,000.00	23,900,000.00
ДТ(131105)	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,400,000.00	23,900,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,519,400,594.24	2,754,284,498.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,519,400,594.24	2,754,284,498.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,249,965,106.50	2,544,380,592.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,237,764,238.29	1,204,603,975.22
210101	Үндсэн цалин	789,603,050.29	773,640,189.22
210102	Нэмэгдэл цалин	359,243,888.00	338,035,674.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,917,300.00	46,956,700.00
210104	Урамшуулал	43,000,000.00	45,971,412.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	153,708,025.04	154,393,188.45
210201	Тэтгэврийн даатгал	106,661,811.58	108,227,653.70
210202	Тэтгэмжийн даатгал	12,493,861.48	12,192,167.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,914,065.10	9,786,155.76
210204	Ажилгүйдлийн даатгал	2,236,047.90	2,193,381.08
210205	Эрүүл мэндийн даатгал	22,402,238.98	21,993,830.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	304,966,646.12	303,401,197.95
210301	Гэрэл, цахилгаан	23,043,223.80	22,637,864.66
210302	Түлш, халаалт	266,583,472.32	264,004,943.29
210303	Цэвэр, бохир ус	15,339,950.00	16,758,390.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,567,471.00	66,604,133.06
210401	Бичиг хэргийн материал	9,156,838.00	3,659,482.00
210402	Тээвэр, шатахууны зардал	3,619,764.00	9,453,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,472,600.00	6,496,391.85
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	3,846,700.00	2,828,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	15,471,569.00	6,175,010.00
2105	Норматив зардал	15,644,098.40	19,728,289.30
210501	Эм	842,100.00	420,000.00
210502	Хоол	14,798,998.40	18,914,745.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000.00	393,544.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,371,942.00	34,470,248.00

Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	24,400.00	
210604	Урсгал засвар	30,347,542.00	34,470,248.00
2107	Томилолт, зочны зардал	603,000.00	458,000.00
210702	Дотоод томилолтын зардал	603,000.00	458,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,094,301.00	42,324,665.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,309,000.00	34,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	820,968.00	1,598,965.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	739,333.00	480,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,000.00	
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	120,000.00	45,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	435,245,384.65	718,396,895.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,694,079.25	66,134,774.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	395,551,305.40	652,262,121.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	269,435,487.74	209,903,906.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	166,667,579.00	117,724,620.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,504,959.00	24,350,400.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	72,659,720.00	90,969,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	53,502,900.00	2,404,720.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	102,767,908.74	92,179,286.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,767,908.74	92,179,286.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	582,063,815.76	3,425,264,004.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,400,000.00	
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	4,400,000.00	
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,282,621.66	197,419.05
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,282,621.66	197,419.05
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4-5)	1,117,378.34	(197,419.05)
7	НИЙТ ҮР ДҮН (7)=(3)+(4)	583,181,194.10	3,425,066,585.75

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,346,405,152.09	7,860,994,073.71	(1,458,987,641.15)	8,749,081,526.65
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,346,405,152.09	7,860,994,073.71	(1,458,987,641.15)	8,749,081,526.65
Тайлант үеийн үр дүн			(94,500,083.91)	(94,500,083.91)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,346,405,152.09	7,860,994,073.71	(1,053,063,121.46)	9,154,336,104.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			460,897.36	460,897.36
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,346,405,152.09	7,860,994,073.71	(1,052,602,224.10)	9,154,797,001.70
Тайлант үеийн үр дүн			3,425,066,585.75	3,425,066,585.75
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,346,405,152.09	7,860,533,176.35	2,372,464,361.65	12,579,402,690.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,120,728,760.00	2,095,480,993.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,712,260.00	10,106,693.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,712,260.00	10,106,693.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,712,260.00	10,009,693.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,712,260.00	10,009,693.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,115,016,500.00	2,085,374,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,112,616,500.00	2,061,474,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,112,616,500.00	2,061,474,300.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,400,000.00	23,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,400,000.00	23,900,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,120,345,460.00	2,094,122,493.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,120,345,460.00	2,094,122,493.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,851,063,851.26	1,884,064,627.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,231,439,767.61	1,199,060,024.60
210101	Үндсэн цалин	769,114,558.61	768,089,239.42
210102	Нэмэгдэл	373,407,909.00	338,042,673.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,917,300.00	46,956,700.00
210104	Үр дүнгийн урамшуулал	43,000,000.00	45,971,412.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,725,290.28	154,393,188.45
210201	Тэтгэврийн даатгал	105,679,076.82	108,227,653.70
210202	Тэтгэмжийн даатгал	12,493,861.48	12,192,167.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,914,065.10	9,786,155.76
210204	Ажилгүйдлийн даатгал	2,236,047.90	2,193,381.08
210205	Эрүүл мэндийн даатгал	22,402,238.98	2,993,830.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	304,966,646.12	303,401,197.95
210301	Гэрэл, цахилгааны зардал	23,043,223.80	22,637,864.66
210302	Түлш, халаалтын зардал	266,583,472.32	264,004,943.29
210303	Цэвэр, бохир усны зардал	15,339,950.00	16,758,390.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,477,609.25	33,887,473.85
210401	Бичиг хэрэг	2,182,900.00	3,095,442.00
210402	Тээвэр, шатахуун	5,118,700.00	5,675,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,472,600.00	6,501,231.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,269,300.00	3,128,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,434,109.25	15,487,400.00
220100	Нормативт зардал	22,692,637.00	42,283,865.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,196,800.00	540,000.00
210502	Хоол, хүнс	17,910,437.00	28,440,865.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,585,400.00	13,303,000.00

Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,789,600.00	39,358,398.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,282,100.00	1,377,500.00
210604	Урсгал засвар	1,507,500.00	37,980,898.00
	Томилолт, зочны зардал	603,000.00	458,000.00
210702	Дотоод албан томилолт	603,000.00	458,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,242,201.00	62,278,965.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,771,000.00	54,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	820,968.00	1,598,965.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	739,333.00	480,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,000.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	805,900.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,127,100.00	48,943,515.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,127,100.00	48,943.515
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	269,281,608.74	210,057,865.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	166,513,700.00	117,878,579.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,351,100.00	24,504,279.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	72,659,700.00	90,969,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	53,502,900.00	2,404,800.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	102,767,908.74	92,179,286.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	102,767,908.74	92,179,286.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	383,300.00	1,358,500.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		1,358,500.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,400,000.00	
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,400,000.00	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,835,300.00	1,358,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,835,300.00	1,358,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,835,300.00	1,358,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,835,300.00	1,358,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(435,300.00)	(1,358,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(52,000.00)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	52,000.00	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,071,474,300.00	1,979,401,706.85	92,072,593.15
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,071,474,300.00	1,979,401,706.85	92,072,593.15
Бараа, үйлчилгээний зардал	1,954,235,700.00	1,862,423,127.85	91,812,572.15
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,258,836,700.00	1,199,060,024.60	59,776,675.40
Үндсэн цалин	815,512,800.00	768,085,239.42	47,423,560.58
Нэмэгдэл	313,616,400.00	338,042,673.18	(24,426,273.18)
Унаа болон бусад нөхөн олговор	51,727,500.00	46,959,700.00	4,770,800.00
Урамшуулал	77,980,000.00	45,971,412.00	32,008,588.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,943,000.00	154,393,188.45	15,549,811.55
Тэтгэврийн даатгал	119,589,500.00	108,227,653.70	11,361,846.30
Тэтгэмжийн даатгал	12,588,400.00	12,192,167.19	396,232.81
ҮОМШӨ-ний даатгал	10,070,700.00	9,786,155.76	284,544.24
Ажилгүйдлийн даатгал	2,517,700.00	2,193,381.08	324,318.92
Эрүүл мэндийн даатгал	25,176,700.00	21,993,830.72	3,182,869.28
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	316,257,400.00	303,401,197.95	12,856,202.05
Гэрэл, цахилгаан	28,807,800.00	22,637,864.66	6,169,935.34
Түлш, халаалт	265,827,500.00	264,004,943.29	1,822,556.71
Цэвэр, бохир ус	21,622,100.00	16,758,390.00	4,863,710.00
Хангамж, бараа материалын зардал	34,042,300.00	32,245,973.85	1,796,326.15
Бичиг хэрэг	3,096,300.00	3,095,442.00	858.00
Тээвэр, шатахуун	2,679,700.00	2,675,400.00	4,300.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,860,000.00	7,144,731.85	1,715,268.15
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,203,900.00	3,128,000.00	75,900.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,202,400.00	16,202,400.00	
Нормативт зардал	43,601,400.00	42,283,865.00	1,317,535.00
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	541,400.00	540,000.00	1,400.00
Хоол, хүнс	29,691,400.00	28,440,865.00	1,250,535.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	13,368,600.00	13,303,000.00	65,600.00
Эд хогшил худалдан авах	39,637,700.00	39,358,398.00	279,302.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,656,800.00	1,377,500.00	279,300.00

Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Урсгал засвар	37,980,900.00	37,980,898.00	2.00
Томилолт, зочны зардал	482,400.00	458,000.00	24,400.00
Дотоод албан томилолт	482,400.00	458,000.00	24,400.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,480,000.00	42,278,965.00	201,035.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,200,000.00	34,200,000.00	
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал	6,000,000.00	6,000,000.00	
Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,598,965.00	201,035.00
Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	480,000.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо			
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			
Бараа үйлчилгээний бусад зардал	48,954,800.00	48,943,515.00	11,285.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,954,800.00	48,943,515.00	11,285.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,238,600.00	116,978,579.00	260,021.00
Бусад урсгал шилжүүлэг	117,238,600.00	116,978,579.00	260,021.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,504,300.00	24,504,279.00	21.00
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	90,969,500.00	90,969,500.00	
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,764,800.00	1,504,800.00	260,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,071,474,300.00	1,979,401,706.85	92,072,593.15
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,061,474,300.00	1,969,295,013.85	92,179,286.15
Улсын төсвөөс санхүүжих	2,061,474,300.00	1,969,295,013.85	92,179,286.15
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	10,106,693.00	(106,693.00)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,106,693.00	(106,693.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
Төсвийн бусад мэдээллийн ангилал			
Ажиллагсдын тоо	91.00	89.00	2.00
Удирдах ажилтан	1.00	1.00	
Гүйлчлэх ажилтан	48.00	46.00	2.00
Үйлчлэх ажилтан	42.00	42.00	
Орон тооны мэдээлэл			
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/			

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		23,900,000.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		23,900,000.00
Бараа, үйлчилгээний зардал		23,000,000.00
Урсгал шилжүүлэг		900,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		23,900,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		23,900,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		900,000.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		23,000,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад жилийн эцсээр өр төлбөр үүсгэхгүй байх, бараа материал, хөрөнгийн эд хариуцагч бүрээр үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгаж байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн хооронд Их наяд аудит ХХК-ийн аудитор М.Энхтуул, аудиторын туслах С.Бямбацэцэг нар гүйцэтгэж, захирал Х.Ариунзул чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Их наяд аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Налайх дүүрэг дэх Политехник коллеж нь байгууллагын эрхэм зорилго нь Нийгмийн түншлэл, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлж, хувь хүний чадамжид суурилсан, мэдээллийн технологид тулгуурласан, ирээдүйг угтсан, насан туршийн боловсрол олгох сургалтын тогтолцоог бий болгож, сургалтын орчныг сайжруулан, багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, төлөвшсөн, чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

- Нийгмийн түншлэл ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх
- Төгсөгчдийг ажлын байраар хангах
- Сургалтын орчинг сайжруулах
- Багшлах боловсон хүчний чадавхийг үе шаттайгаар дээшлүүлэх
- Гадаад харилцаагаа өргөжүүлж, төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Налайх дүүрэг дэх Политехник коллежид дээд шатны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,519,400.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,194.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,430,408.3 мянган төгрөгөөр буюу 37.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	408.5	408.5
Бараа материал	393,920.9	393,666.8	(254.1)
Үндсэн хөрөнгө	8,760,576.1	12,190,830.0	3,430,253.9
Нийт хөрөнгө	9,154,497.0	12,584,905.3	3,430,408.3
Өр төлбөр	160.9	5,502.6	5,341.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,154,336.1	12,579,402.7	3,425,066.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,154,497.0	12,584,905.3	3,430,408.3

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл нь 408.5 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон авлагаар нэмэгдсэн;
- Бараа материалын данс нь “Хашхан” ХХК-аас хандиваар авсан болон худалдан авалтаар нийт 140,392.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 102,084.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 37,991.8 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өсөлт нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд 4,081,355.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан ;
- Өр төлбөрийн данс өмнөх оноос ХХОАТ 5,456.4 мянган төгрөг, “Дашваанжил” ХХК-д төлөх 46.2 мянган төгрөгийн тооцооны үлдэгдлээр нэмэгдсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,151,871.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,151,871.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 90,397.2 мянган төгрөгөөр бууруулан 2,061,474.3 мянган төгрөгөөр баталсан ба төсвийн тодотгол хийгдээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 15-19 насны хүүхдүүдийн тусгай мэргэжил олгох 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,061,474.3 мянган төгрөг, өөрийн орлогоор 10,000.0 мянган төгрөг нийт 2,071,474.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,061,474.3 мянган, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 10,106.7 мянган, нийт 2,071,581.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,979,401.7 мянган төгрөгийг зарцуулж, 92,179.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71804	Ерөнхий боловсрол	2,071,474.3	1,979,401.7	92,179.3	95.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,890,344.3	1,799,782.3	(90,562.0)	96.0
1.2	81806	Дотуур байрны үйлчилгээ	29,691.4	28,440.8	(1,250.5)	94.0
1.3	80219	Харуул хамгаалалтын зардал	34,200.0	34,200.0	-	100.0
1.4	80802	Бусад урсгал шилжүүлэг	117,238.6	116,978.6	(260.0)	99.8

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,979,401.7 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал 91,812.6 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 260.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд камер байрлуулах ажлын 23,900.0 мянган, манай хороо миний гудамж аяны шагналаас 900.0 мянган, нийт 23,900.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс бараа материалын зардал 3,000.0 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 20,000.0 мянган, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 900.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Налайх дүүрэг дэх Политехник коллежийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 4 арга хэмжээний хэрэгжилт 97.5 хувь, хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.6 хувийн биелэлттэй, 1.9 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагыг тулган шалгахад анхаарах асуудал гараагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус коллежийн дотуур байранд амьдарч байгаа 15-19 насны хүүхдүүдийн хоол хүнсний нэг хүүхдэд ногдох норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж нормативыг Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2005 оны 225/296 тоот тушаалын тавдугаар хавсралтаар баталсан байна.

Уг нормативын зардал нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, шимт бодис, амин дэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай” тушаалаар батлагдсан хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэгийн хэмжээнд нийцэхгүй, зөрчилдөж байгаа тул хүүхдүүдийн хоол хүнсний норм, нормативыг шинэчлэх талаар анхаарч, цаашид шаарлагатай арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 3,074,459,315.17 төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулж, 7 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргаж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Нягтлан бодогч Л.Пүрэвжаргалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тэмцээн уралдаан, баяр ёслолын зардал, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх”, гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Монгол Улсын Засгийн газрын 43-р тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 135,409.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад 135,409.3 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2 төлбөрийн актын 2,284.6 мянган төгрөгийг төлж барагдуулсан, шилэн дансны цахим хуудсанд 13,053.0 мянган төгрөгийн 2 мэдээг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд 1 албан шаардлага биелэлт 90 хувь, 9,735.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,284.6	2	2,284.6			100%
Албан шаардлага	1	13,053.0	1	13,053.0			90%
Зөвлөмж	2	9,735.0	2	9,735.0			100%
Нийт дүн	5	25,072.6	5	25,072.6			96.6%

Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өгсөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 7 гүйлгээг мэдээлээгүй зөрчлийг арилгаж холбогдох мэдээллийг хоцроон байршуулсан зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч авч үзэх асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,816.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,502.6 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгуулахаар албан шаардлага, 7,314.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 12,816.7 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 12,377.3 мянган төгрөгөөр бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2 Албан шаардлага

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 5,502.6 мянган төгрөгийн ХХОАТ болон бараа материалын тооцооны өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өр, авлага үүсгэхгүй байх, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Оны эцэст хүнсний бараа материал /мах/ их хэмжээгээр нөөцөлж 7,314.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр худалдан авч нөөц үүсгэхгүй байж, төсвийн дагуу худалдан авч хэтрэлт гаргахгүй ажиллаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
						Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:														
1	Налайх дүүрэг дэх Политехник коллеж	АХГ-2022/242/НА-СТА-ТШЗ	Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 5,502.6 мянган төгрөгийн ХХОАТ болон бараа материалын тооцооны өглөг үүсгэсэн байна.	1	5,502.6					1	5,502.6			
2	Налайх дүүрэг дэх Политехник коллеж	АХГ-2022/242/НА-СТА-ТШЗ	Оны эцэст хүнсний бараа материал /мах/ их хэмжээгээр нөөцөлж 7,314.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.	1	7,314.1								1	7,314.1
Дүн				2	12,816.7					1	5,502.6			1 7,314.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:														
1	Налайх дүүрэг дэх Политехник коллеж	АХГ-2022/242/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд оруулбал зохих 3,074,459,315.17 төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулж, 7 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргаж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна	1	-					1	-	1	-	
2	Налайх дүүрэг дэх Политехник коллеж	АХГ-2022/242/НА-СТА-ТШЗ	Тэмцээн уралдаан, баяр ёслолын зардал, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.	1						1	-			
Дүн				2						2	-			
Нийт дүн				4	12,816.7					3	5,502.6	1	-	1 7,314.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 167/АД150058
АХГ-2022/272/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тэмцээн уралдаан, баяр ёслолын зардал, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" 1.6 Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

1. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайх дүүрэг дэх Политехник коллежийн захирал С.Мөнхбат, нягтлан бодогч Л.Пүрэвжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
М.ЭНХТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.20\Bichig\Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-173.Docx

0010800572



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 165/А0150058
АХГ-2022/242/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 5,502,624.80 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар болон бараа материалын тооцооны өглөг үүсгэсэн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаж, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өр, авлага үүсгэхгүй байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Налайх дүүрэг дэх Политехник коллежийн захирал С.Мөнхбат, нягтлан бодогч Л.Пүрэвжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		Б.СЭРЖМЯДАГ
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР		М.ЭНХТУУЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 166/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/242/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайх дүүрэг дэх Политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 3,074,459,315.17 төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулж, 7 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргаж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлэх журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч Л.Пүрэвжаргалд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Налайх дүүрэг дэх Политехник коллежийн захирал С.Мөнхбатад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.СЭРЖМЯДАГ

ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

М.ЭНХТУУЛ

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-172.Docx

0010800568

